





УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

БОДЛОГО • ХУУЛЬ, ЭРХЗҮЙ • ШИНЭЧЛЭЛ • ТӨСӨЛ



# УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## 2020-2021



mmhi.gov.mn

# ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР



# 01 БОДЛОГО 02 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ 03 ШИНЭЧЛЭЛ 04 ТӨСӨЛ

2021 оны эхний 10 сарын байдлаар

**30.4%**

Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 30.4 хувийг бүрдүүлж байна.

**↑ 2.2**

Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 3,724 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 2,028 тэрбум төгрөг буюу 2.2 дахин өсөв.

**12,236**

тэрбум төгрөг

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 12,236 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 3,979 тэрбум төгрөг буюу 48.2 хувиар өссөн.

**3,724**

тэрбум төгрөг

# СЭТГҮҮЛИЙН ХУРААНГУЙ

4

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ 2020-2021



08 ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ  
БАРИМТЛАХ ТӨРИЙН БОДЛОГО

10 ГЁНДОН: ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТ,  
БОЛОВСРУУЛАЛТ, БОРЛУУЛАЛТ,  
ХУВААРИЛАЛТ ГЭСЭН ЦОГЦ  
БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛНЭ

14 О.БАТНАЙРАМДАЛ: ҮНДЭСНИЙ  
БАЯЛГИЙН САНГИЙН ХУУЛЬТАЙ  
БОЛСНООР МЕГА ТӨСЛҮҮД  
УРАГШЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН  
БҮРДЭНЭ

17 ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН  
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

22 ЭРДЭС БАЯЛГИЙН ЦАХИМ  
ЗАСАГЛАЛ

24 ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ  
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

37 ҮЙЛ ЯВДЛЫН  
ХУРААНГУЙ

# ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН БОДЛОГО ОЛБОРЛОЛТООС БОЛОВСРУУЛАЛТАД

Уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 69 хувь, экспортын 93 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 хувийг бүрдүүлдэг бөгөөд Монгол Улсын эдийн засгийн суурь салбар болон хөгжжээ. Үүнээс сүүлийн 30 жилд уул уурхайн салбар гадаад зах зээл, дэлхийн түүхий эдийн зах зээлийн үнийн мөчлөгөөс ихээхэн хамааралтай болсныг монголчууд бид мэддэг болсон. Тиймээс энэхүү онцлогийг харгалзан, ирж яваа цагийг угтан эрдэс баялгийн салбарт баримталж буй бодлогоо өргөн хүрээтэй, тодорхой болгож, чамбайруулах учиртайг “Ковид-19” цар тахлын цаг үе тод томруун мэдрүүлж байна.

Цар тахлын дараах эдийн засгийн сөргөлт нь олон улсын зах зээл дээр түүхий эдийн үнийн өсөлт бий болгож буй гол хүчин зүйлүүдийн нэг гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч байна. Энэ бол түүхий эдийн экспорт давамгайлсан манай улсын хувьд том төслүүдээ хөдөлгөх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах нэн таатай цаг үе юм. Тиймээс УУХҮЯ-ны баг хамт олон “Алсын хараа 2050” бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилтуудаа тууштай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бодлогын баримт бичгүүдэд туссан томоохон зорилтуудыг хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг тууштай нэмэгдүүлж, уул уурхайн салбарт нэмүү өртөг шингээн, ажлын байрыг бий болгож олборлолтоос боловсруулах салбар болгон хөгжүүлэхээр хууль эрх зүйн шинэчлэл, цахим шилжилтийг эхлүүлээд байна.

Хариуцлагатай, нээлттэй, ил тод, үр ашигтай уул уурхайг хөгжүүлэхэд шинэ зууны хөгжлийн хурдасгуур болсон “Аж үйлдвэрийн 4.0 хувьсгал”-д суурилсан цахим шилжилт чухал үүрэгтэй. УУХҮЯ хайгуулын шатнаас эхлээд уурхай хаах хүртэлх бүхий л үе шатанд тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг цахимаар хүргэхээр манлайлан ажиллаж буй бөгөөд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл болон Ашигт малтмал,

газрын тосны газар, Үндэсний геологийн алба зэрэг төрийн байгууллагуудын цахим системийн уялдаа холбоо, удирдлага, зохион байгуулалтыг өндөр түвшинд ханган ажиллаж байна.

Эрдэс баялгийн цахим засаглал нь “хяналт”, “ил тод, нээлттэй байдал”, “технологийн дэвшил, инновац” гэсэн гурван түвшний үр дүнд хүрэх учиртай. Мөн 2019 онд баталсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, түүнийг дагасан хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Хүнд үйлдвэрлэлийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслүүдийг УИХ-аар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Эдгээр хуулийг баталснаар уул уурхайн баялгийг иргэн бүрд хүртээх, хөрөнгө оруулалт, бизнесийн орчин сайжрах, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ цэн өсөх, үүнийг дагаад эдийн засгийн бусад сектор хөгжих зэрэг өргөн хүрээний ач холбогдолтой юм. Мөн стратегийн ач холбогдол бүхий нөөц нь тогтоогдсон томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэхээс гадна дэд бүтцийг барьж байгуулах, нүүрс баяжуулах, газрын тос, зэсийн баяжмал, төмөрлөг боловсруулах үйлдвэрийн томоохон төслүүдийг хэрэгжүүлж байна.

Улирч буй жил гаруйн хугацаанд хийгдсэн онцлох ажлуудыг багцлан хүргэх, эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар нэгдсэн мэдээлэл өгөх үүднээс энэхүү тайлан сэтгүүлийг танд хүргэж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД



Гэлэнгийн ЁНДОН

**Уул уурхай,  
хүнд  
үйлдвэрийн  
салбарт  
боловсруулах  
үйлдвэрийн  
бүтээн  
байгуулалт  
өрнөж,  
нэмүү өртөг  
шингэсэн  
бүтээгдэхүүн  
үйлдвэрлэл  
хөгжинө.**

# ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ ТӨРИЙН БОДЛОГО

ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛ

## 01

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА**

### ХАЙГУУЛ



#### БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ҮНЭЛГЭЭ

- Байгалийн баялаг
- Геологийн судалгаа
- Нарийвчилсан хайгуул
- Ашигт малтмалын нөөц

## 02

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА**

### ОЛБОРЛОЛТ



#### ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ, ЗАРДАЛ БУУРУУЛАЛТ

- Ордын нөөцийг сорчлохгүй ашиглах
- Уурхайн өргөтгөл, шинэчлэлт
- Баяжуулалтын шилдэг технологи
- Уул уурхайн цахим шийдэл
- Хаалтын иж бүрэн менежмент

# 03

ХҮНД ҮЙЛДВЭРИЙН  
ТУХАЙ ХУУЛЬ

## БОЛОВСРУУЛАЛТ



### ГҮН БОЛОВСРУУЛАЛТ, НЭМҮҮ ӨРТӨГ, АЖЛЫН БАЙР

- Газрын тос боловсруулах үйлдвэр
- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр
- Гангийн үйлдвэр
- Нүүрс баяжуулах үйлдвэр

# 04

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ

## БОРЛУУЛАЛТ



### ЭРДЭС БАЯЛГИЙН БИРЖ

- Дэлхийн зах зээлийн үнэ
- Шударга, тэгш өрсөлдөөн
- Ил тод, нээлттэй арилжаа

# 05

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН  
ТУХАЙ ХУУЛЬ


## ХУВААРИЛАЛТ



### ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН

- Ирээдүйн өв сан
- Хөгжлийн сан

## ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТ, БОЛОВСРУУЛАЛТ, БОРЛУУЛАЛТ, ХУВААРИЛАЛТ ГЭСЭН ЦОГЦ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛНЭ



**У**ул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонтой салбарын бодлого, эрх зүйн орчны өөрчлөлт, шинэчлэлт, дэд бүтцийн бүтээн байгуулалт, зах зээлийн чиг хандлага, боловсруулах үйлдвэрлэлийн талаар ярилцлаа.

**-Олон жил яригдсан Эрдэс баялгийн бирж байгуулах ажлыг УУХҮЯ урагшлуулж эхэллээ. Дахин саатах эрсдэл байгаа юу, жишээ нь түүхий эдийн дундын зуучлагчдын зүгээс эсэргүүцэлтэй тулгарч байгаа байх. Үүнээс ярилцлагаа эхэлье?**

-Эрдэс баялгийн биржийн эрх зүйн орчинтой болох ажил өмнөх жилүүдэд үр дүнгүй болж, удааширч байсан нь улс төрийн шийдвэр гардаггүй байсантай холбоотой. Харин одоо бол биржийн эрх зүйн орчныг бий болгох, бирж байгуулах хамгийн таатай нөхцөл бүрдээд байна. Хэдийгээр тодорхой хүрээнд, тухайлбал, дундын зуучлагчид болон худалдааны компанийн зарим төлөөлөл эсрэг байр суурь илэрхийлж байсан ч, хэлэлцүүлгийн явцад дэмжиж буй иргэд болон төрийн бус байгууллагууд их байсныг хэлэх хэрэгтэй болов уу. Мөн Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нарын түвшинд дэмжигдсэн. Одоо УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлэн болоод байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд

төрийн өмчит компаниуд бүтээгдэхүүнээ биржээр дамжуулан зарж борлуулахаар хуульчилж байгаа. Хувийн хэвшлийнхний хувьд сонголт нь нээлттэй.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн гарц, гол баталгаа нь эрдэс баялгийн салбар болж байна. Тиймээс уул уурхайн бүтээгдэхүүний экспортын үнэ шилэн хоргонд байгаа мэт ил тод, нээлттэй байх ёстой. Тэгж байж иргэд байгалийн баялгийнхаа эзэн байх боломж бүрдэнэ. Тухайлбал, Оюутолгойн ордын нөөцийн тодорхой хэсэг танд болон надад, бас бусад иргэнд ч ногдож байгаа. Тэгэхээр танд ногдсон тэр баялгийг хэн, ямар үнээр зарж байгааг бид мэдэх эрхтэй шүү дээ. Дэлхийд уул уурхайн бараа бүтээгдэхүүний биржүүд ингэж л ажилладаг. Монголын хөрөнгийн биржийн системд ч зөөлөн дэд бүтэц нь бэлэн байгаа.

**-Уул уурхайн салбарын өнөөгийн хөгжлийг та хэрхэн дүгнэх вэ. Мөн яам цаашдын хөгжлийн бодлогоо хэрхэн тодорхойлсон бэ?**

-Монголын уул уурхайн салбар ирэх онд 100 нас хүрнэ. Гадаадын уул уурхайтай харьцуулахад балчир хүүхэд л дээ. Гэхдээ социализмын бүтээн байгуулалтын он жилүүдэд уул уурхайн салбар Монгол Улсыг босгож, өндийлгэж, хөгжүүлж ирсэн. Эрдэнэт үйлдвэр, Багануур, Бор-Өндөр, Шарын гол гээд олон сайхан уурхай тэр үеийн нийгэм, эдийн засгийн амьдралыг үүрч авч явсан. Одоо ч хэвээр.

Миний хувьд салбартаа 31 дэх жилдээ ажиллаж байна. Ихэнх хугацааг нь хөдөө орон нутагт, уурхайд ажиллаж өнгөрүүлсэн. Зах зээлд шилжсэн сүүлийн 30 жилийн хугацааг харахад манай салбар үсрэнгүй хөгжсөн гэж хэлж болно. Гадаадын хөрөнгө оруулалт идэвхжиж, хувийн хэвшлийн үүрэг, оролцоо нэмэгдэж тэр хэрээр уул уурхайн салбарын хөгжил эрчимжсэн. Өнгөрсөн хугацаанд хайгуул, олборлолт амжилттай сайн хийгдэж, "Оюутолгой", "Цайрт минерал" гэх мэт уул уурхайн шинэ хөрөнгө оруулалтууд мөн бүтээн байгуулалтууд өрнөснийг нэрлэж болно. Харин одоо манай салбар хөгжлийн шинэ шатанд

**Монгол Улсын тогтвортой хөгжлийн гарц, гол баталгаа нь Эрдэс баялгийн салбар юм.**



гарах цаг болсон байна. Хайгуул, олборлолтын түвшнээс ахиж, боловсруулах салбараа эрчимтэй хөгжүүлэхэд бид бодлогоо чиглүүлж, улмаар борлуулалт, хуваарилалт гэсэн цоо шинэ тогтолцоог бий болгохоор зорьж байгаа.

“Баялагтаа эзэн монгол” байх, байгалийн баялгийн үр өгөөжийг иргэн бүрд хүргэх арга замыг манай салбар, бид маш ойлгомжтой, тодорхой харж байна. Өнөөдөр үйлчилж байгаа зарим хууль болон эрх зүйн орчинд цаг үеийн болон нийгмийн захиалгаар шинэчилсэн найруулга хийх, мөн бодлогодоо тохирсон зарим анхдагч хуулийн төслүүдийг шинээр өргөн барьж батлуулснаар бодлогын шинэчлэл буюу **хайгуул – олборлолт – боловсруулалт – борлуулалт – хуваарилалт** гэсэн цогц бодлого хэрэгжих ёстой гэж үзсэн.

Уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулдаг болсноор дахин шинэ ордыг нээж ашиглахтай дүйцэх хэмжээний ашиг орлого олох боломжтой. Дахин нөхөгддөггүй эрдэс баялаг, уул уурхайд энэ их чухал асуудал. Гүн боловсруулалт хийх явцад ажлын байр шинээр бий болж, нэмүү өртөг шингээж, төсөвт орох татварын орлого нэмэгддэг. Мөн үүнийг дагаад кластераар хөгжих боломж, ЖДҮ, бичил бизнес эрхлэх нөхцөл гээд дараа дараагийн шатны үйлдвэрлэл хөгжих орчин бүрддэг.

Би ярилцлагын эхэнд хэлсэн, Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтыг биржийн тухай хуулиар зохицуулах бол байгалийн баялгаас орж ирэх орлогыг иргэдэд тэгш шударга хуваарилж, ирээдүйн хөгжилд үр дүнтэй зарцуулах ажлыг Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар зохицуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

**-Яамны зүгээс хэд хэдэн хуулийн төсөл бэлтгэж байна. Онцолж асуухад, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга өмнөхөөсөө юугаараа ялгаатай вэ?**

-1997 онд анх баталсан Ашигт малтмалын тухай хууль бол нэлээд либерал үзэл санаатай, тэр хэрээр гадаадын хөрөнгө оруулалтыг татсан. Нэг жишээ нь Оюутолгой. Хөрөнгө оруулалт нь Монголын эдийн засагт том нөлөө

үзүүлснийг бүгд мэднэ. Ковидоос үүдсэн эдийн засгийн хүндрэлтэй цаг үед Оюутолгойгоос орж ирсэн орлогоор иргэн бүрд 300 мянган төгрөгийн нэг удаагийн дэмжлэг үзүүлсэн нь уул уурхайн баялгийн нэг хуваарилалт юм. Мөн Эрдэнэт үйлдвэр иргэдийн цахилгаан, дулаан, ус, хогны төлбөрийг төлж байна. “Эрдэнэс Тавантолгой” компани анх удаа ногдол ашиг тараалаа. Уул уурхайн баялгийн хуваарилалт энэ мэт байдлаар 2021 онд өрх болгонд, иргэн бүрд хүрсэн.

Харин 2006 онд шинэчлэн найруулсан Ашигт малтмалын тухай хууль өнөөдрийг хүртэл үйлчилж байгаа. Энэ хуульд 300 гаруй удаа өөрчлөлт оруулсан бөгөөд зарим үед явцуу ашиг сонирхолтой, тодорхой бүлэглэлийн захиалга ч орсон гэгддэг.

Одоо бол нийгэм, цаг үеийн захиалгаар салбарынхаа асуудлыг томоор харж, энэ хуулийг шинэчлэх цаг нь болсон байна. Уул уурхай бол төсвийн орлогын дөрөвний нэгийг бүрдүүлдэг, эдийн засгийн тулгуур салбар учраас бид хуулиа сайжруулах ёстой. Одоо байгаа маш олон гацааг арилгаж, салбарын хөгжлийг дараагийн шатанд гаргах нь зүй ёсны асуудал болж байна. Нөгөө талдаа, уул уурхайн салбар байгаль орчныг бохирдуулдаг, нөхөн сэргээдэггүй, хүмүүсийн амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлдэг гээд муу нэртэй болж. Гэтэл бодит байдал дээр энэ бүх муу дүрийг бий болгох “тоглолтууд” ч бас явагдсан. Иргэний нийгмийн нэрийг барьсан явцуу эрх ашгийн үүднээс эх орончийн дүр эсгэдэг зарим нэгэн хэсэг бүлэг хүмүүсийн хийсэн ажил салбарын хөгжлийг хойш татсан. Мөн Ашигт малтмалын тухай хуульд ашигт малтмал ашигласны 10 хувийг суманд, 20 хувийг аймагт, 70 хувийг нэгдсэн төсөвт орно гэж заасан ч, хэрэгжээгүй. Энэ заалт хэрэгжвэл уул уурхай байршдаг тухайн сум, орон нутгийн хөгжилд маш их нэмэртэй. Орон нутагт уул уурхайг зөв өнцгөөр харах шинэ уур амьсгал бий болно. Тиймээс энэ заалтыг хэрэгжүүлэхийн тулд бид Засгийн газрын түвшинд зөвшилцөж, нэг бодлогоор зангидах зайлшгүй шаардлага байна.

**Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох асуудалд нээлттэй, ил тод, шударга, тэгш өрсөлдөх боломжоор хангах зарчмыг баримтална.**

**ТЭЗҮ, нөөцийн тайлан хүлээн авах, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулав.**

АМНАТ-ын 30 хувийг аймаг, суманд нь үлдээх асуудлыг хуулиар зохицуулж, шийдэж байж уул уурхайн салбарт тулгардаг олон асуудал, бэрхшээл багасна. Цаашлаад орон нутаг нь өөрөө төсвөө бүрдүүлэхэд илүү санаачилгатай ажиллах болно.

**-Орон нутгийн эрх мэдэл, оролцоо нэмэгдэх нь. Тэгэхээр ашиглалтын тусгай зөвшөөрөл авах үйл явцыг хэрхэн хянах вэ. Үүнтэй холбоотой ямар өөрчлөлт гарч байгаа вэ?**

-Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход илүү хариуцлагатай, өндөр шаардлага тавина. Ашиглалтын лиценз эзэмшигчийн хариуцлагыг өндөрсгөж, хатуу шалгууртай заалтыг хуулийн төсөлд тусгасан. Харин хайгуул дээр нэлээд либерал бодлого баримтална. Хайгуулын лицензийг сонгон шалгаруулалтаар болон өргөдлөөр олгохоор хуулийн төсөлд тусгаад байна. Мэдээж олон удаагийн хэлэлцүүлгээр орно, зөвшилцөнө, өөрчлөгдөнө. Мөн өргөдөл ихээхэн хэл ам, маргаан дагуулдаг тул цахимжуулж, мэргэжлийн шаардлага тавьж, нээлттэй болгохоор ажиллаж байна. Яамны зүгээс тусгай зөвшөөрөл олголт, хайгуулын болон уулын ажлын тайлан төлөвлөгөө зэрэг иргэд, аж ахуйн нэгжүүдэд чирэгдэл учруулдаг үйл явцыг бүрэн цахимжуулж байна. Цахим засаглал бол манай геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт эрчтэй нэвтэрч байгаа. Одоогоор ТЭЗҮ, нөөцийн тайлан хүлээн авах, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг цахимжуулаад байна.

Үүнээс гадна ТЭЗҮ гэдэг шиг байгаль орчны үнэлгээг тогтоох Нийгэм, эдийн засгийн үндэслэл буюу НЭЗҮ-тэй болж байгаа. Тухайн орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулахаар болвол сум, багийн иргэд болон

хөдөөгийн хөгжилд ямар үр нөлөөтэй байхыг тооцож гаргана. Бага нөөцтэй хэр нь их хэмжээний газар талхалж болохгүй шүү дээ. Ганцхан хүний эрх ашгийг хангахын тулд бүхэл бүтэн аймаг сумын иргэдийн эрх ашгийг зөрчиж болохгүй гэдэг санаа. Тиймээс тухайн орон нутагт ашиггүй бол ашиглалтын лиценз олгохгүй. Тиймээс үүнийг хэмжихийн тулд бид НЭЗҮ-г нэмж оруулсан. Мөн мөнгөн урсгалууд нь ил тод, ордыг ашигласнаар бий болох үр дүн нь тодорхой байх ёстой. Тухайлбал, малчдын өвөлжөө, хаваржаа орчимд яалт ч үгүй олборлолт хийхээр бол тухайн нутгийн иргэдэд нөхөн төлбөр олгох гэх мэт ашиглалттай холбоотой үүсдэг асуудлуудыг шийдэх зохицуулалтыг энэ удаагийн хуулийн шинэчлэлд өргөн хүрээтэй тусгахаар зорьж байгаа. Өөрөөр хэлбэл, хариуцлага чангарна гэсэн үг.

Хайгуулын хувьд, сүүлийн жилүүдэд лиценз олноор нь цуцалсан боловч сонгон шалгаруулалтаар шинээр олгох нь тун цөөхөн байгаа учир цаашид нэмэгдүүлнэ. Хайгуулын ажил олон улсад 10-20 жилээр ашиглалтаасаа түрүүнд явдаг. Энэ нь салбарын хөгжилд чухал үүрэгтэй. Гэтэл манайд хайгуулын 900 тусгай зөвшөөрөл байхад, ашиглалтынх нь 1,700 орчим байна. Тиймээс хайгуулын салбарт илүү либерал бодлого баримтална гэдгээ давтан хэлье.

**-Нүүрсний экспортыг нэмэгдүүлэх ажлууд шат дараатай урагшилж байна. Үүний нэг нь чингэлэгт тээвэр гэж ойлгож байгаа. Үр дүнгийн хувьд та ямар хүлээлттэй байгаа вэ?**

-Нүүрсний хувьд аль болох их хэмжээтэй, хурдан борлуулах ёстой гэсэн бодлого барьж байна. Дэлхий дахин нүүрс төрөгч ялгаруулахаас татгалзаж байна. Манай нүүрсний гол зах зээл болох Хятад улсын нүүрсний хэрэглээ 2026 онд оргилдоо хүрч, улмаар алгуур бууруулж, 2060 он гэхэд нүүрс төрөгчийг агаарт гаргахгүй байх бодлого барьж байна. АНУ, Герман улс ч ялгаагүй хязгаарлаж, нүүрс олборлолтоо зогсоохоо мэдэгдээд байна. Дэлхий дахины чиг хандлага ийм байгаа учраас бид удахгүй шахалтад орох нь. Иймд бид нүүрсээ тодорхой хэмжээнд амжиж борлуулах хэрэгтэй. Үүнээс гадна нүүрсийг аль болох баяжуулж, гүн боловсруулах чиглэлээр хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй гэж би хувьдаа боддог. Ингэж байж нүүрсийг хатуу түлш хэлбэрээр шатаахаа болино гэсэн үг. Шингэрүүлсэн шатдаг хийнээс эхлээд каучук гэх мэт олон төрлийн бүтээгдэхүүнийг нүүрснээс гарган

**Тусгай зөвшөөрлийн тоо**  
2020.10.01-ний байдлаар





Гашуунсухайт дахь чингэлэгт тээврийн терминалын үйл ажиллагаатай танилцав. 2021.09.21

авдаг. Бензин хүртэл гаргаж байна. Иймд бид нүүрсийг гүн боловсруулах чиглэлд ажиллана. “Эрдэнэс Тавантолгой” ХК Тавантолгойн ордод Үйлдвэр технологийн паркийн хүрээнд нүүрс-химийн цогцолбор барих төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Чингэлэгт тээврийн терминал нь 24 цагийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулах юм. Терминалын ачиж, буулгах тоног төхөөрөмж, техникийн хүчин чадлыг талбайн чингэлэгт тээврийн эрчимтэй уялдуулж үе шаттай нэмэгдүүлнэ. Ингэснээр терминалаас экспортлох нүүрсний хэмжээ 8-19 сая тонн хүртэл өсөх бүрэн боломжтой. Нүүрс бол манай улсын экспортолж буй уул уурхайн хамгийн том биет бүтээгдэхүүн. Нүүрсийг ачих болгонд хаягдал, бохирдол, хорогдол ихээр үүсдэг. Үүнээс үүдэн эдийн засгийн болон байгаль экологийн сөрөг үр дагавар гарч байна. Тиймээс уртын болон богинын тээврийн ачилтын цагийг давхцалгүйгээр зохион байгуулж, жолооч нар хоорондоо харилцаа үүсгэхгүйгээр терминалаар дамжин тээвэрлэлт хийхээр зохицуулснаас гадна нүүрсний тээвэрлэлтээс үүдэлтэй байгаль орчинд учирч буй сөрөг нөлөөлөл багасах юм.

Мөн Шивээхүрэнгийн боомтод ийм терминал байгуулахаар Засгийн газрын тогтоол гарч бүтээн байгуулалтын ажил шуурхай эхэлсэн бөгөөд одоо дуусах шатандаа орлоо. Цаашдаа бусад бүх боомт дээр чингэлэгт тээврийн терминал байгуулах боломжтой. Энэхүү чингэлэгт тээврийн терминалууд

шинээр байгуулагдах биржийн салшгүй хэсэг дэд бүтэц нь болох бүрэн боломжтой.

### **-Салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ямар бодлого баримтлах вэ?**

-Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт буурахад хүргэсэн хэд хэдэн шалтгаан бий. Нэгдүгээрт, хайгуулын тусгай зөвшөөрөл олголт хумигдсанаар гадаадын хөрөнгө оруулагчид монголоос гарсан. Хоёрдугаарт, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж чадаагүй. Их хэмжээний хөрөнгө зарцуулж хайгуул хийгээд, сая нэг олборлолт явуулахаар орон нутагт очиход нь нутгийн иргэд хүлээж авахгүй эсэргүүцэх, элдэв дарамт шахалт үзүүлэх гэх мэт зөрчлүүд их гардаг. Энэ удаагийн хуулийн өөрчлөлтийн хүрээнд тухайн компани лиценз авсан бол уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулах орчныг баталгаатай болгоход чиглэж байгаа. Гадаадын аль нэг компани орон нутагт олборлолт явуулж, хуулийн дагуу бүх төлбөрөө улсад төлөөд явдаг ч яг тухайн орон нутагт өгөөж нь мэдрэгддэггүй тул хөрөнгө оруулагчдыг буцаагаад гаргачихдаг тохиолдол олон бий. Тиймээс хүмүүсийн нүдэнд тухайн компанийн оруулсан хөрөнгө илүү ил тод харагддаг байх нь чухал. АМНАТ-ын 10 хувийг суманд, 20 хувийг аймагт нь үлдээгээд эхэлбэл иргэд аяндаа уул уурхайн үйл ажиллагааг ойлгож, дэмжиж эхэлнэ. Энэ нь цаашлаад улсын хөгжилд томоохон гарц, хөшүүрэг болно.

**Гашуунсухайт дахь чингэлэгт тээврийн терминал ашиглалтад орсноор нүүрсний экспорт жилд 8-19 сая тн өсөх боломжтой.**

# ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

“Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын үнийн мэдээлэл шилэн хоргонд байгаа мэт ил тод, нээлттэй байх ёстой. Монгол хүн байгалийн баялгийнхаа эзэн байх боломжийг Үндэсний баялгийн сангийн тухай хууль болон бусад хууль эрх зүйн орчноор бүрдүүлнэ.







### ХАЙГУУЛ

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга

### ОЛБОРЛОЛТ

Ашигт малтмалын тухай хууль

### БОЛОВСРУУЛАЛТ

Хүнд үйлдвэрийн тухай хууль

### БОРЛУУЛАЛТ

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль

### ХУВААРИЛАЛТ

Үндэсний баялгийн сангийн тухай хууль



## Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.”



## Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоол:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Ил тод хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ.”

## ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ХУУЛЬТАЙ БОЛСНООР МЕГА ТӨСЛҮҮД УРАГШЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДЭНЭ



**У**ХУ-ийн дэд сайд О.Батнайрамдалтай Үндэсний баялгийн сангийн хуулийн төслийн талаар ярилцлаа.

**-Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Хуулийн төслийн үзэл баримтлал юу вэ?**

-Монгол Улсын Үндсэн хууль, “Алсын хараа -2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг баримт бичигт байгалийн баялгийн өгөөжийг Үндэсний баялгийн сангаар дамжуулан ард түмэндээ тэгш, шударгаар хүртээх зорилт тусгагдсан. Дэлхийд 130 гаруй Үндэсний баялгийн сан 9.3 орчим их наяд ам.долларын хөрөнгийг удирдаж байна. Өөрөөр хэлбэл дэлхийн санхүүгийн салбарт эргэлдэж буй нийт хөрөнгийн бараг 10 хувийг удирдаж байна гэсэн үг.

Баялгийн сангууд тухайн орны онцлог, зорилго, шийдэж буй асуудлаас хамаарч хэд

хэдэн төрөлтэй байдаг. Тухайлбал, Сингапур улс төрийн өмчит компаниудаа зах зээлийн зарчмаар удирдах чиг үүрэг бүхий “Темасек Холдинг” баялгийн санг 1974 онд байгуулж байсан бол 1981 онд гадаад валютын нөөцөө зохистой удирдах, худалдан авах чадварыг хадгалах зорилгоор Сингапурын засгийн газрын хөрөнгө оруулалтын корпорацийг байгуулж байв.

Манай Улсын хувьд 2010 онд Төсвийн тогтворжуулалтын сан, 2016 онд Ирээдүйн өв сангийн тухай хуулийг баталж, мөрдөж ирсэн. Мөн Үндсэн хуульд хууль тогтоомжийг нийцүүлэх тухай УИХ-ын 2020 оны 2 дугаар тогтоолд Үндэсний баялгийн сан нь хуримтлалын болон хөгжлийн сангийн төрөлтэй байна гэж заасан. Энэ нь Баялгийн сангийн нэг төрөл болох Хөгжлийн санг олон улсын сайн туршлагын дагуу шинээр байгуулах бодит хэрэгцээ шаардлага үүссэн гэсэн үг.

Энэ нь нэг талаас уул уурхайн томоохон төрийн өмчит компаниудыг хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогоор хангах, дэлхийн хэмжээний чадварлаг менежментийн баг зах зээлийн зарчмаар удирдаж хөрөнгийн арвижуулах, үргүй зардыг танаж засаглалыг сайжруулах, төрд ногдох ногдол ашгийг дорвитой нэмэгдүүлэх, нөгөө талаас, уул уурхайн компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн мега төслүүдийг хөдөлгөх, цаашлаад урт хугацаандаа эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэхэд чиглэсэн тэргүүлэх салбаруудын санхүүгийн үр ашигтай хөрөнгө оруулалт хийх зорилготой. Ингэснээр цаашид Монгол Улсын хөгжлийг тодорхойлох томоохон хөрөнгө оруулалтуудыг төсөвт дарамт болохгүйгээр, зах зээлийн зарчмаар тогтвортой хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. “Эрдэнэс Монгол” ХХК байгуулагдаад 14 жил болж байгаа ч, 10 гаруй охин болон хараат компаниас ердөө 2-3 нь л үр ашигтай ажилладаг. Төрийн өмчит уул уурхайн томоохон компаниудыг эзэмшдэг “Эрдэнэс Монгол” ХХК олон улсын баялгийн сангийн хэлбэр, зохицуулалт, стандарт руу цаг алдалгүй яаралтай шилжиж орох ёстой. Ингэж байж хөрөнгийг оновчтой, зорилготой удирдлагаар хангана.

**Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар төрийн өмчит компаниудын ил тод байдал, засаглалыг сайжруулна.**

**Дотоодын эдийн засгийг хэт халахаас сэргийлж, аж үйлдвэрийн салбарт үе шаттай хөрөнгө оруулалт хийнэ.**

Аль хөрөнгөө урт хугацаандаа өөрөө эзэмшиж, аль хэсгийг нь хувийн хэвшилтэй хамтран удирдах нь зүйтэй вэ, мөн зарим компанийхаа эзэмшлийн тодорхой хувийг үе шаттайгаар гадаад болон дотоодын хөрөнгийн бирж дээр арилжаалж нээлттэй, олон нийтийн болгох гэх мэт хөрөнгө оруулалтын стратегиа багцын хүрээнд маш сайн судалгаатай, мөн оновчтой тодорхойлж шийдвэр гаргаж явах ёстой. Үндэсний баялгийн сан болон Хөгжлийн сангийн тухай хуулиуд энэ бүхнийг бодитоор хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох юм. Төрийн өмчийн томоохон хувьчлал, эсвэл олон нийтэд нээлттэй болгох үйл ажиллагааг яаран, хүчээр хийж болдоггүйг бидний өнгөрсөн түүх нэг биш удаа харуулсан тул одоо маш нухацтай хандах шаардлагатай.

Энэ хуулиар зохицуулагдаж буй өөр нэг чухал зүйл бол засаглал, ил тод байдал. Сайн засаглалгүйгээр, ил тод нээлттэй үйл ажиллагаагүйгээр ямар ч компани, тэр тусмаа төрийн өмчит үйлдвэр, компаниуд өндөр үр ашигтай ажиллах боломжгүй. Тиймээс олон улсын сайн засаглалын туршлагыг нэвтрүүлэх хэрэгтэй. Өнөөдөр бидэнд тулгарч буй засаглалын асуудал зөвхөн Монголд тулгарч байгаа асуудал биш юм. Улс бүр л хөгжлийн аль нэг шатандаа дайраад л өнгөрсөн байдаг. Харин үүнийгээ хэрхэн амжилттай шийдвэрлэж чадсан эсэхээр тухайн орны хөгжлийн дараагийн үе шат, өнгө төрх шууд хамаардаг. Тиймээс бид энэхүү хуулиа бичиж байхдаа дэлхийн сайн, муу туршлагыг олон талаас харьцуулан судалж, энэ тал дээр дотоод, гадаадын мэргэжлийн экспертүүдтэй нягт хамтран ажиллаж байгаа.

**-Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг “Эрдэнэс Монгол” ХХК эзэмшдэг. Тэгэхээр тус компанийн статус ямар болно гэсэн үг вэ?**

-Хөгжлийн сан (холдинг компанийн хэлбэр) болно. Өөрөөр хэлбэл Сингапурын “Темасек холдинг”, Казахстан улсын “Самрук-Казына” зэрэг баялгийн сангийн загварт шилжинэ гэсэн үг. Төрийн өмчит томоохон уул уурхайн хөрөнгүүд нь “Эрдэнэс Монгол” ХХК, УУХҮЯ, ТӨБЗГ гэх мэт олон газар зэрэг хамаардгаас нэгдсэн удирдлага, бодлого дутагдаж байна. Тиймээс уул уурхайн энэ олон тарсан хөрөнгийг нэгдсэн бүтэцтэй болгож, хөрөнгө оруулалтын сангийн зарчмаар удирдсанаар:

**Нэгдүгээрт:** Хөрөнгө оруулалтын нэг цонхны нэгдсэн бодлогоор хангана

**Хоёрдугаарт:** Охин болон хараат компаниудын

санхүүгийн сахилга бат сайжирч, үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэнэ.

**Гуравдугаарт:** Нэмүү өртөг шингээх, уул уурхайн компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, цаашлаад уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгийн бүтэцээс алхам алхмаар ангижрах томоохон хөрөнгө оруулалтууд хийгдэнэ.

Үндэсний баялгийн сан нь эдийн засгийн урт хугацааны өсөлтийг хангах, ард түмэндээ байгалийн баялгийн үр өгөөжийг тэгш, шударга хүртээх, хараат бус бие даасан байх, ил тод нээлттэй байх, нийгмийн хариуцлагатай байх гэсэн таван зарчмыг баримталж ажиллахаар хуульд тусгасан. Хөгжлийн сан нь эдийн засагт чухал хувь нэмэр оруулахын зэрэгцээ хойч үедээ өвлүүлэн үлдээх бодлогын хүрээнд Ирээдүйн өв санд ногдол ашгиа хуваарилах юм.

**-Хөгжлийн сангийн удирдлага ямар бүтэцтэй байх вэ? Засаглалыг нь эрүүл байлгах тал дээр ямар зохицуулалт орж байгаа вэ?**

-Баялгийн сангийн хувьд удирдаж буй хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шийдвэр гаргах, нэг талаас гүйцэтгэх удирдлагуудад дэмжлэг үзүүлдэг, нөгөө талаас хяналт тавьдаг мэргэжлийн, хараат бус байнгын ажиллагаатай ТУЗ-тэй байна. Засаглал талаасаа сангийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, хараат болон охин компаниудын гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг, эрх хэмжээг хуулиар маш тодорхой болгоно. Тэдгээр эрх бүхий албан тушаалтнуудад тавигдах шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн нээлттэй ил тод сонгон шалгаруулдаг, салбартаа бодит өөрчлөлт авчирсан арвин туршлагатай, хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг мэргэжилтнүүд байна гэж тусгасан. Нөгөө талаас УИХ, Засгийн газрын эрх хэмжээ, хязгаарлалтуудыг нарийн тодорхой заана. Ингэснээр Хөгжлийн сан болон төрийн өмчийн уул уурхайн компаниудыг улс төрийн нөлөөлөл, цаг үеийн гал унтраах шийдвэрүүдээс хамгаалж чадна.

**-Байгалийн баялгийн өгөөжийг бэлэн мөнгөөр тарааж, эдийн засагт хэт халалт үүсгэсэн гашуун түүх бидэнд бий. Үндэсний баялгийн сангийн хөрөнгө төслүүдэд чиглэснээр эдийн засагт ямар давуу тал үүсэх вэ?**

Бэлэн мөнгө хавтгайруулж тарааснаас эдийн засагт ямар эрсдэл үүсдгийг бид бүгд ойлгосон. Энэ нь цаашлаад зөвхөн эдийн засаг гэлтгүй нийгмийн сэтгэл зүйд доройтол үүсгэх зэрэг олон асуудал дагуулдаг. Нөгөө талаас, уул уурхай түшиглэсэн улс орнуудад нийтлэг





Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг танилцуулав. 2021.09.03

тохиолддог Голланд өвчин болон баялгийн хараалаас сэргийлэх талаар бид бодолцож үзсэн. Дотоодын эдийн засгийг хэт халахаас сэргийлэхийн зэрэгцээ аж үйлдвэрийн салбарт үе шаттайгаар хөрөнгө оруулалт хийнэ. Өөрөөр хэлбэл, Хөгжлийн сан маань төсвийн орлогоос булаацалдахгүй, одоо байгаа төрийн өмчит уул уурхайн компаниудыг зах зээлийн зарчмаар удирдаж ашигт ажиллагааг нэмэгдүүлж, улмаар бий болох ашгийг хуримтлуулж, түүгээрээ хөрөнгө оруулалт хийх юм. Хөгжлийн сан байгуулагдсанаар макро эдийн засагт дунд болон урт хугацаанд хэрхэн нөлөөлөхийг бид ерөнхий тэнцвэрийн динамик загвараар (CGE) бас тооцоолсон. Өнөөдөр Баялгийн сан, Хөгжлийн сангийн эрх зүйн зохицуулалт, нэгдсэн хөрөнгө оруулалтын бодлого байхгүйгээс стратегийн ач холбогдол бүхий томоохон төсөл хөтөлбөрүүдийг нэг удаагийн Засгийн газрын тогтоол, шийдвэрээр санхүүжүүлж байгаа нь учир дутагдалтай. Тухайлбал, Тавантолгойн цахилгаан станц, төмөр зам зэрэг томоохон хөрөнгө оруулалтуудыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Эрдэнэс Тавантолгой” ХК-д даалган санхүүжүүлж буй нь мөнгөн урсгал сайтай хэдхэн компаниуддаа хэт их ачаалал өгч, тэдний санхүүгийн бие даасан байдал, компанийн цаашдын хөгжилд чөдөр тушаа

болдог. Тиймээс эдгээр үйлдвэр, компанийг хөгжлийнхөө дараагийн шатанд гарах, санхүүгийн сахилга бат, бие даасан байдалтай байх, эрх хэмжээнийхээ хүрээнд төлөвлөсөн дэд төслүүдээ хэрэгжүүлэх боломж нөхцөлөөр хангах хэрэгтэй. Тэрхүү томоохон санхүүжилтийн механизм нь Хөгжлийн сан юм.

**-Баялгийн сангийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах тал дээр хуулийн төсөлд ямар зохицуулалтууд орж байгаа вэ?**

-Баялгийн санг зөв удирдах, ил тод байдлыг хангах нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын зарчмууд бий. Дэлхийн олон жишиг баялгийн сангууд нэгдэж чуулаад Үндэсний баялгийн сангуудын олон улсын форум зохион байгуулсан байдаг. Энэ хүрээнд Баялгийн сангийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэхэд баримтлах нийтлэг 24 заалт бүхий Сантьягогийн зарчмыг баталсан байдаг. Дэлхий дээр хамгийн амжилттай ажилладаг баялгийн сангууд сайн засаглал, оновчтой удирдлагатай ажиллахын тулд Сантьягогийн зарчмыг мөрддөг. Бид бас тэдгээр зарчмыг Хөгжлийн сангийн тухай хуульдаа тусгаж өгсөн.

**Үйлдвэр, компаниудыг хөгжлийн дараагийн шатанд гарах, эрх хэмжээнийхээ хүрээнд төлөвлөсөн дэд төслүүдээ хэрэгжүүлэх боломж нөхцөлөөр хангах хэрэгтэй.**

# УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ

**У**ул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны А/93 дугаар тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж ажилласан. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай анхдагч хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсрууллаа.

Эл хууль нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг ил тод, нээлттэй зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтоох боломжийг бүрдүүлэх, экспортыг нэгдсэн бодлогоор хангах замаар уул уурхайн салбарт хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд энэ салбарын оруулах хувь нэмрийг улам өргөжүүлэх эрхзүйн ач холбогдолтой.

**Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, худалдаа арилжаанд олон хүндрэлтэй, шийдвэрлэвэл зохих асуудлууд тулгарч байна.**

- Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн бодит үнэ, худалдааны нөхцөл, бүтээгдэхүүний чанарын талаарх мэдээлэл ил тод бус байдгаас үр ашигтай гэрээ хэлцэл хийх боломж муу, зардал өндөр байна.
- Уул уурхайн бүтээгдэхүүнийг борлуулах зохион байгуулалттай зах зээл бий болоогүйн улмаас бүтээгдэхүүний үнэ ханш дэлхийн зах зээлийн үнээс доогуур байна.
- Гэрээний үндсэн дээр арилжаалагдах уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ нь гэрээний үнээр тогтоогдож, хууль тогтоомжийн дагуу албан татвар, төлбөр, хураамж ногдож байна. Гэвч гэрээгээр тохирсон үнэ нь зах зээлийн ханшаас нэлээд зөрүүтэй байдгаас уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас олох орлогыг ихээхэн бууруулж байна.



## Р.Очбадрах

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөх,  
Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагч


## Биржийн тухай хуулиас хүлээх үр дүн

- Монгол Улсад уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулах эрх зүйн орчин бүрдэж, улмаар бүтээгдэхүүний нийлүүлэгч, худалдан авагчийг холбох найдвартай тогтолцоо бий болж, зах зээлийн бодит ханш тогтох, арилжааны болон гэрээ, хэлцлийн мэдээлэл олон улсын зах зээлд нээлттэй зарлагдсанаар хөрөнгө оруулагчид найдвартай мэдээллээр хангагдана. Мөн Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.
- Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, борлуулалтын хэмжээ ил тод болсноор арилжаанаас тооцох татвар хураамжийг үндэслэлтэй тогтоох нөхцөл бүрдэж улсын төсвийн орлого нэмэгдэнэ.
- Уул уурхайн бүтээгдэхүүнийг нийлүүлэх гэрээний үүргийн хэрэгжилт баталгаатай болж арилжаанд оролцогчдын эрсдэл буурах, хөрөнгө оруулалтын таатай орчин бий болох ач холбогдолтой.

- Биржийн арилжааны төлбөр тооцоо Монгол Улсын банк санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж, гадаад валютын орлого нэмэгдэж, ханш тогтворжих таатай нөхцөл бүрдэнэ.
- Уул уурхайн бүтээгдэхүүний чанар олон улсын стандартын түвшинд хүрч сайжрах бөгөөд үүнийг дагаад техник, технологийн шинэчлэл хийгдэх, шинээр ажлын байр бий болох нөхцөл бүрдэнэ.
- Биржийг дагалдан арилжааны зуучлагч, тээвэр логистик, баталгаат агуулах, даатгал зэрэг цогц үйлчилгээ бий болно. Энэ нь уул уурхайн бүтээгдэхүүний зохион байгуулалттай зах зээлийн найдвартай, тогтвортой ажиллагааг дэмжихийн эрэгцээ татварын суурийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад тогтоомжтой нийцүүлэн боловсруулсан бөгөөд Бирж нь төрийн өмчит компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан нийт дөрвөн хуульд нэмэлт өөрчлөлт оруулна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна.



## АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТҮҮХЭН ТОВЧ ХУРААНГУЙ

**Ө**нгөрсөн 30 жилийн хугацаанд геологи, уул уурхайн салбарын хамгийн гол хууль болох Ашигт малтмалын тухай хуулийг 1994 онд анх баталж, 1997, 2006 онд тус тус шинэчлэн найруулжээ. Ашигт малтмалын тухай хууль батлагдсанаар зах зээлийн нийгмийн үед геологи, уул уурхайн салбарыг зохицуулах эрх зүйн шинэ харилцаа, орчин бүрдсэн юм.

*АМТХ нь "Алт" хөтөлбөр эрчимтэй хэрэгжих бололцоог бүрдүүлсэн. 1991 онд алтны олборлолт жилд 800 кг байсан бол "Алт" хөтөлбөрийг баталж хэрэгжүүлснээр 2001 онд 13 тоннд хүрч нэмэгдэж байсан юм.*

- **1994 он.** Ашигт малтмалын тухай хуулийг Үндсэн хуулийн үзэл баримтлалтай нийцүүлж баталсан.
- **1997 он.** Ашигт малтмалын тухай хууль шинэчлэн батлагдсанаар хайгуул, ашиглалтын цоо шинэ эрх зүйн орчин бий болж, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах боломж бүрдсэн.

*Уг хууль хэрэгжсэнээр 2006 он хүртэлх хугацаанд Монгол улсын нийт газар нутгийн 44 хувьд нь 6000 орчим хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдож, хайгуулын үйл ажиллагаа ихээхэн идэвхжсэн.*

*2000 оны дунд үе гэхэд Монгол улс дэлхийн хайгуулын ажлын нийт санхүүжилтийн 4 хувийг татсан байдаг.*

- **2006 он.** 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийг өөрчлөх нийгмийн шахалт бий болж, 1994, 1997 оны хуулийн үзэл баримтлалд тусгагдсан асуудлыг нэгтгэн боловсруулж гаргасан. Уг хуульд төрийн оролцоог оруулсан нь Үндсэн хуулийн 6.1 заалтыг хэрэгжүүлэх оролдлого байв. Энэ хуульд өмнөх хуульд байгаагүй зарчмын хэд хэдэн өөр зохицуулалт нэмэгдсэн. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ангилал бий болж, уг ангилалд багтсан ордыг ашиглахад төр хувь эзэмшиж оролцохыг хуульчилсан.

### Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга салбарт цогц зохицуулалтыг бий болгоно

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий төр болон хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг багтаасан Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын



2020 оны А/332 дугаар тушаалаар байгуулсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр зайлшгүй Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Эрдэс баялгийн салбарт үйлчилж буй 10 хуульд дүн шинжилгээ хийж, нийт 267 давхардал, 150 зөрчил, 150 хийдэл буйг тогтоож, шийдвэрлэх шаардлагатайг тодорхойлсон юм. Мөн “Монгол улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын 131-д “Ашигт малтмалын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2021 онд боловсруулахаар тусгасан. Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 14 дүгээр хуралдааны тэмдэглэлд “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан уг хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлээр холбогдох хуулиудын төслийг боловсруулж, Улсын Их хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан. Энэ дагуу Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах зайлшгүй шаардлага тулгарсан.

## Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын гол үзэл баримтлал нь

1. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулах
2. Эрдэс баялгийн салбарт үйлчилж байгаа хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах
3. “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан уг хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх
4. Салбарын шинэчлэлийг зайлшгүй хийх гэсэн асуудал байна.

## Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн найруулснаар ямар эерэг үр дүн гарах вэ?



### Б.Элбэгзаяа

УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга, Ашигт малтмалын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагч

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалт, баяжуулалт, борлуулалт, байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, уул уурхайн эрсдэлийн удирдлага, орон нутгийн уялдаа холбоо зэрэг бүхий л асуудлыг хамрах бөгөөд салбарын удирдлагын тогтолцоог цогцоор шийдсэн эрх зүйн зохицуулалттай болно. Үүнд:


- Уул уурхайн үйл ажиллагаа эрэл, хайгуулын шатнаас эхлэн төлөвлөгдөж хаагдах хүртэлх бүх үе шатанд нээлттэй, ил тод, хариуцлагатай уул уурхайн тогтолцоог олон улсын чиг хандлагад нийцүүлснээр байгаль орчны хамгаалал нэмэгдэх, нутгийн удирдлагын болон олон нийтийн оролцоо хангагдана.

- Уурхайн хаалтын шинэ тогтолцоог санхүүгийн баталгааны механизмтай уялдуулахаар төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр уул уурхайн үйл ажиллагаанд өртсөн аливаа газар нөхөн сэргээгдэхгүйгээр эзэнгүй орхигдох эрсдэл багасна.
- Олон улсын шилдэг техник, технологийг нэвтрүүлэн аливаа эрсдэлийг тооцоолдог болсноор уул уурхайн хөгжлийг дэмжиж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.
- Учирч болох аливаа эрсдэлийг бууруулснаар уул уурхайн үйлдвэрлэлийн хэмжээ, үр ашиг тогтвортой нэмэгдэж, улс, орон нутгийн төсөвт орох орлого нэмэгдэн эдийн засгийн чадавх, баталгаа сайжирна.

Хайгуулын салбар нь асар их хөрөнгө оруулалт шаарддаг. Уул уурхайн үйлдвэрлэлээс дор хаяж 10 жилээр түрүүлж явагдаж байх учиртай тус салбарын хөрөнгө оруулалт өнөөдөр хангалтгүй байна. Хэдийгээр хайгуулын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтаар олгож байгаа ч, шинээр олгож буй тусгай зөвшөөрлийн тоо цөөн байна. Тухайлбал, 2020 онд 40 хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон бөгөөд нэг тусгай зөвшөөрлийг олгоход шаардагдах хугацаа дунджаар 35 хоног байна. Иймд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг илүү нээлттэй байдлаар олгохоор тусгаж буй. Олборлолтоос боловсруулалт руу шилжиж байгаа өнөөгийн түүхэн цаг үе, ирээдүйн хөгжлийг Ашигт малтмалын тухай хууль зураглана.

## АШИГТ МАЛТМАЛЫН УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

Ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна. (2021 I - X сар)




Зэс  
**1,420.8 (2.8 дахин)**  
тэрбум төгрөг



Хайлуур жонш  
**68.7 (3.5 дахин)**  
тэрбум төгрөг




Нүүрс  
**230.7 (48.3%)**  
тэрбум төгрөг



Цайр  
**64.0 (3.3 дахин)**  
тэрбум төгрөг



Төмөр  
**101.2 (2.6 дахин)**  
тэрбум төгрөг



Алт  
**50.9 (36.1%)**  
тэрбум төгрөг

## УИХ, ЗАСГИЙН ГАЗАРТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮД



- » УИХ-ын 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийг батлуулсан.
- » Уул уурхайн бүтээгдэхүүнийн биржийн тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулан Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.
- » Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулан Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.

- » Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж дараах хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулж байна.

- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл
- Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
- Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл

### Шинээр баталсан дүрэм, журам



Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шинэчилсэн дүрэм



Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам



Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам



Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам



Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журам

## “ЦАХИМ ҮНДЭСТЭН” БА ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ЦАХИМ ШИЛЖИЛТ

**М**онгол Улсын Засгийн газраас “Цахим үндэстэн” болох томоохон зорилтыг дэвшүүлж, амжилттай хэрэгжүүлж буй бодлогын нэг нь ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ЦАХИМ ШИЛЖИЛТ юм. “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд цахим шилжилтийг ухаалгаар хийж, энэ чиглэлд мэргэжлийн албан хаагчдын оролцоо, хүлээх үүргийг оновчтой болгон зохион байгуулахаар Засгийн газраас тууштай арга хэмжээ авч ажиллаж байна.

УУХҮЯ-наас эрдэс баялгийн салбарын үр өгөөж, бүтээмжийг нэмэгдүүлэн, төрийн үйлчилгээг нээлттэй, хүнд сурталгүй, хариуцлагатай хөгжүүлэх зорилтыг дэвшүүлэн цахим шилжилтийн бодлого хэрэгжүүлж байна.

УУХҮЯ, АМГТГ, ҮГА-наас иргэд, ААН, төрийн холбогдох байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээний өнөөгийн байдал дүн шинжилгээ хийж, уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг сайжруулах, нэг системд нэгтгэх, үүний тулд мэдээллийн системийн дэд бүтцийг хөгжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох төлөвлөгөөтэй ажиллаж байна.



**Г. Нандинжаргал**  
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны  
Төрийн нарийн бичгийн дарга



УУХҮЯ-ны Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтэс.





## Цахим шилжилтийн бодлогын хүрээнд

УУХҮЯ дотоод бүтэцдээ Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтсийг байгуулж, дараах ажлуудыг хэрэгжүүлэв.

- УУХҮЯ-наас аж ахуйн нэгжид олгодог тусгай зөвшөөрлийн бүртгэлийн систем хөгжүүлэлтийг хийж нэвтрүүлсэн. Систем нэвтрүүлснээр газрын тос, тэсэлгээ, хүнд үйлдвэрийн чиглэлийн 13 төрлийн тусгай зөвшөөрлийг цахимаар олгох нөхцөлийг бүрдүүлж байна. Ингэснээр ААН-үүд тусгай зөвшөөрлийн явц ямар шатандаа явааг хянах боломжийг бүрдүүлсэн.
- ТЭЗҮ, геологи хайгуулын ажлын тайлан төлөвлөгөө, ордын нөөц зэргийг хэлэлцдэг эрх бүхий гол байгууллага нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ). Тус зөвлөлийн үйл ажиллагааг цахимжуулсан нь ААН, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талархлыг хүлээж байна.
- Төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулж, шийдвэр гаргалтыг шуурхай болгох үүднээс УУХҮЯ-ны удирдлагын мэдээллийн цахим систем /mobile application/-ийг нэвтрүүлэв.

Цахим шилжилтийн хүрээнд салбарын 400 гаруй мэргэжилтнийг хамруулсан “Эрдэс баялаг - Цахим шилжилт” арга хэмжээг 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдөр цахимаар зохион байгуулав.



# ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

26

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ 2020-2021



ЗЭСИЙН БАЯЖМАЛ  
БОЛОВСРУУЛАХ  
ҮЙЛДВЭР



→  
ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ  
ҮЙЛДВЭР



→  
НҮҮРС БАЯЖУУЛАХ  
ҮЙЛДВЭР



→  
ХАР ТӨМӨРЛӨГИЙН  
ЦОГЦОЛБОР



# ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

## /2020-2024 он/



**Дорноговь  
аймгийн  
Алтанширээ  
суманд  
баригдаж буй  
Газрын тос  
боловсруулах  
үйлдвэрийн  
төсөл  
амжилттай  
хэрэгжиж  
байна.**

27

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ 2020-2021

**Б**НЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 2017 оноос эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

### Үйлдвэрийн бүтээн байгуулалт дараах 4 үе шатаас бүрдэнэ

- 01** EPC1 Технологийн бус барилга байгууламж, ус дамжуулах хоолой, үйлдвэрийн талбайн дэд бүтцийн бэлтгэл
- 02** EPC2 Анхдагч процессийн болон дагалдах байгууламжууд
- 03** EPC3 Үйлдвэрийн цахилгаан станц
- 04** EPC4 Гүн боловсруулалтын лицензтэй технологийн байгууламжууд



УУХУ-ийн сайд Г.Ёндон ГТБҮ-ийн төслийн талбайд ажиллалаа.

## 2020-2021 онд хийсэн ажлууд


“Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн төслийг ХЗДХЯ, СЯ, УУХҮЯ, АМГТГ, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг боловсруулж, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-ын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэнгээр ахлуулсан ажлын хэсэг байгуулж, тухайн хууль болон дагалдан гарах хуулийн төслийг УИХ-ын 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн батлуулав.

Газрын тос боловсруулах үйлдвэр болон тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн технологийн ба дагалдах туслах байгууламжийг барьж, ашиглалтад оруулахад төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох зорилгоор “Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг боловсруулан Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар батлуулав.



Газрын тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх сонирхолтой компанийг сонгон

шалгаруулалтад оролцох хүсэлт ирүүлэх урилгыг олон улсад нэр хүнд бүхий Pipeline and Gas Journal сайтад 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдөр нийтлүүлсэн. Төсөл хэрэгжүүлэх сонирхолтой гадаад, дотоодын 20 орчим компани урьдчилсан сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ төслийг санхүүжүүлэх товч саналын хамт ирүүлсэн ба 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр газрын тос дамжуулах хоолойн тендерийг нээж, үнэлгээний ажил явагдаж байна.



Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Дорнод аймгийн Матад, Халх гол сумдын нутаг дэвсгэрт орших Тамсагийн сав газарт байрших газрын тосны хайгуулын Давст XXXI талбайг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-д олгох тухай тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсан.

**Дэд бүтцийн ажлын хүрээнд 27 км төмөр зам, 17.5 км хүнд даацын автозам, 110кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын бүтээн байгуулалтын ажлуудыг 2019 онд дуусгаж, хүлээлгэн өгсөн.**



### Хүчин чадал

Жилд 1.5 сая тн газрын тос боловсруулах  
ҮЙЛДВЭРЛЭЛ /Евро-5 стандарт/



Автобензин  
**339 мян.тн**



Дизель түлш  
**824 мян.тн**



Онгоцны түлш  
**80 мян.тн**



Шингэрүүлсэн шатдаг хий  
**43 мян.тн**



Зуухны түлш  
**47 мян.тн**

### Төслийн явц

- Инженерчлэл, зураг төсөл боловсруулах ажил үе шаттай хийгдэж байна.
- Технологийн бус байгууламжийн (ЕРС-1) ажлын гэрээг 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр байгуулж, ажлыг 2021 оны 3 дугаар сард эхлүүлсэн.

- Технологийн байгууламжуудын барилга угсралтын ажлын (ЕРС-2,3) Ерөнхий гүйцэтгэгчийн урьдчилан сонгон шалгаруулалт явагдаж байна.
- 550 айлын хотхоны эхний ээлжийн орон сууцны барилгын ажил 90%-тай байна.
- Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил (төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах агаарын шугам)-ын ажил хийгдэж дууссан.

### Нийгэм, эдийн засгийн ач холбогдол

- Бүтээн байгуулалтын хугацаанд 6000 хүнийг ажлын байраар хангана.
- Цаашид үйлдвэрт 600 тогтмол ажлын байр бий болно.
- Түлш, шатахууны импортын хамаарлаас гарна.
- Шатахууны үнэ импортын шатахуунаас 15-20 хувь хямд байх боломж бүрдэнэ.
- Нефть-химийн аж үйлдвэрийн шинэ салбар бий болно.
- Шатахууны дотоодын хэрэгцээний 55-60 хувийг хангана.
- Гадаад худалдааны алдагдал \$1.0 тэрбум орчмоор буурна.

# ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛ /2020-2024 он/

30

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ 2020-2021

## Ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн завод


**М**онгол Улсын Засгийн газрын 2020- 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэл хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлнэ гэсэн зорилт дэвшүүлсэн. Уурхайн түвшин доошилж, олборлолт хийхэд хүндрэлтэй болохоос гадна хүдрийн агуулга буурч, зардлын хэмжээ нэмэгдэж байна. Иймд үйлдвэрийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах зорилгоор өргөтгөл, шинэчлэлийн ажлыг эхлүүлээ.

**Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгал тээврийн технологийн металл хийц үйлдвэрлэлийн ажлын явц, бутлуурын байгууламж 100%, туузан дамжуургын систем 100% дууссан.**

## Ордын ашиглалтын нөөц /2021.01.01-ний байдлаар/



Хүдэр  
**1277.0 сая тн**



Зэс  
**5255.7 мян.тн**



Молибден  
**213.5 мян.тн**

## 2020-2021 онд хийсэн ажлууд



### Ил уурхай

- Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгал тээврийн технологийн металл хийц үйлдвэрлэлийн ажлын явц, бутлуурын байгууламж 100%, туузан дамжуургын систем 100% дууссан.
- Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгал тээврийн технологи нэвтрүүлэлт 40 хувьд хүрсэн.

### Төслийн явц

#### Механик тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн явц:

Бутлуурын байгууламж 90%, туузан дамжуургын систем 85% байна. Нийт механик тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн ажлын явц 17%-ийн гүйцэтгэлтэй байна.

### Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн хөрөнгө оруулалт 100 хувь шийдэгдсэн ба үйлдвэрийн бүтээн байгуулалт 65% байна.



### Хүчин чадал



### Баяжуулах үйлдвэр

Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажил 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар бүтээн байгуулалтын газар шорооны ажлын явц 98%, барилгын бетон цутгалт 95%, төмөр хийцийн нийлүүлэлт 100% байна.

Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 99%-тай байгаа ба тоног төхөөрөмжүүдийн угсралтын ажил хийгдэж байна.

### Нийгэм, эдийн засгийн ач холбогдол

- **Ажлын байр:** 137
- **Конвейер:** Хүдэр тээвэрлэлтийн зардлыг 20 хүртэл хувиар бууруулна.
- **Баяжуулах үйлдвэр:** Хүдэр боловсруулалтын хүчин чадлыг 32 сая тн-оос 40 сая тн болгон нэмэгдүүлж, хүдэр боловсруулах өртгийг 10 хүртэл хувиар бууруулна.
- **Засвар механикийн завод:** Эрдэнэт үйлдвэрийн тоног төхөөрөмжийн эд анги, сэлбэг хэрэгслээр хангаж, импорт орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дотоодын зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

# УУЛ УУРХАЙ-МЕТАЛЛУРГИ-ХИМИЙН ҮЙЛДВЭРИЙН ЦОГЦОЛБОР, ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК /2020-2023 он/

32

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ 2020-2021

**Төслийн  
нарийвчилсан  
ТЭЗҮ, БОННУ,  
техник,  
технологийн  
түвшний  
үнэлгээ зэрэг  
судалгааны  
ажлууд бүрэн  
хийгдэж  
дууссан.**

## Паркийн дэд бүтэц, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, катодын зэсийн үйлдвэр

Үйлдвэрлэл технологийн парк нь зэсийн баяжмалыг дотооддоо боловсруулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, цаашид эрэлт, хэрэгцээ нь өсөн нэмэгдэж буй зэс хоолой, эд анги, өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бүрдүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бий болох зэрэг нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой төсөл юм.

## 2020-2021 онд хийсэн ажлууд

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах Үйлдвэрлэл, технологийн паркийн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Орхон аймгийн ИТХ-ын ээлжит бус II хуралдаанаар хэлэлцүүлж, нийт 1217.4 га газарт ҮТП байгуулахаар тогтов.


Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, паркийн хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахаар тогтон дэд бүтцийн ажлыг эхлүүлэв.



Төслийн нарийвчилсан ТЭЗҮ, БОННУ, техник, технологийн түвшний үнэлгээ зэрэг судалгааны ажлууд бүрэн хийгдэж дууссан.

ҮТП-ийн дэд бүтцийн хүрээнд төмөр зам, авто зам, цахилгаан, дулаан, ус хангамжийн байгууламжуудыг барих ба зураг төсөл боловсруулах, цахилгаан хангамжийн ТЭЗҮ боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байна.

Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын China ENFI Engineering тэргүүтэй консерциум 2019 онд боловсруулсан бөгөөд тус ТЭЗҮ-ийг 2020 онд шинэчлэн боловсруулж, элементийн хүхрийн технологийн үйлдвэрлэлийн туршилтын ажлын үр дүнгээр ТЭЗҮ-д тодотгол хийхээр ажиллаж байна.



Эрчим хүчний яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ зэрэг байгууллагын төлөөллөөс бүрдсэн “Уул уурхай-металлурги химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтыг хийхэд холбогдох төрийн байгууллагууд хоорондын ажлын уялдаа холбоог хангах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн А/99 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.





### Хучин чадал

Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр:



Баяжмал  
**560.0 мян.тн**



Катодын зэс  
**124.1 тн**



Мөнгө  
**38 тн**



Элементийн хүхэр  
**181 мян.тн**

- **КЗҮ:** 2016 онд ТЭЗҮ боловсруулж, ЭБМЗ-өөр хэлэлцүүлсэн. Одоо ТЭЗҮ-ийн тодотгол хийгдэж байна.

### Нийгэм, эдийн засгийн ач холбогдол

- Эхний 20 жилийн хугацаанд дээрх 4 төсөл 46 их наяд төгрөгийн орлого олж 3.9 их наяд төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллана.
- Улсын төсөвт эдгээр төслүүд НӨАТ болон ААНОАТ-аар 1.4 их наяд төгрөгийг төвлөрүүлнэ.
- ДНБ-ийг 360 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ.
- Шинээр 1070 ажлын байр бий болно.
- Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулж, аж үйлдвэрийн кластерыг хөгжүүлнэ.
- Эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- Катодын зэсийн дотоодын үйлдвэрлэл, экспортын орлого нэмэгдэж дагалдах жижиг дунд үйлдвэрлэл хөгжинө.

### Төслийн явц

- **ҮТП:** Дэд бүтцийн зураг төслийн ажил хийгдэж байна.
- **ЗББҮ:** 2019 онд ТЭЗҮ боловсруулж, одоо ТЭЗҮ-ийн тодотгол хийж байна.

# НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР

## /2020-2024 он, эхний шат/

**Э**рдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр баригдсанаар нүүрсийг нэмүү өртөг шингээн баяжуулж, ордыг иж бүрэн ашиглах боломж бүрдэхийн зэрэгцээ ажлын байр, улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, хураамж, орлогыг нэмэгдүүлэх, цаашлаад Монгол Улсын иргэдийн эзэмшиж байгаа 1072 хувьцааны үнэ цэн нэмэгдэх боломж бүрдэнэ.



### “Эрдэнэс тавантолгой” ХК

/2010 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд/

Цанхийн Зүүн болон Баруун уурхайгаас нийт 75 сая тн нүүрс олборлож, 9 их наяд төгрөгийн мөнгөн дүн бүхий 71 сая тонн нүүрс борлуулж, улсын төсөвт 2.2 их наяд төгрөгийн татвар, хураамж төвлөрүүлсэн байна.



### 2020-2021 онд хийсэн ажлууд

Монгол Улсын Засгийн газрын 2020- 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна” гэж тусгагдсан бөгөөд энэхүү арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд ордыг түшиглэн баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж, ашиглалтад оруулах тогтоолын төслийг УУХҮЯ боловсруулж, Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанд танилцуулж, батлуулсан.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгойн ордод түшиглэсэн баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргасан.

“Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх” түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй нээлттэй тендерийг холбогдох журмын дагуу 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдөр зарлаад байна.

2021 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 16 хуулийн этгээд тендер шалгаруулалтад оролцох хүсэлт ирүүлэн тендерийн баримт бичиг болон ажлын даалгавар, техникийн зураг, баримт бичгүүдийг хүлээн авсан. Эдгээрээс 4 аж ахуйн нэгж тендер шалгаруулалттай холбоотой тодруулга, хүсэлт ирүүлсэн ба Үнэлгээний хороо тухай бүрд нь хэлэлцэн шийдвэрлэж байна.



## Хүчин чадал

Баяжуулсан нүүрс  
**30 сая тн**

- 2025 оноос хойш 540.1 сая ам.доллар хөрөнгө оруулалт хийж, нүүрс баяжуулах үйлдвэрийн 20 сая тн хүчин чадалтай 2, 3-р модулийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.
- Нүүрс баяжуулах үйлдвэрт шаардлагатай усны эх үүсвэр, түүний шугам хоолой, барилгын ажлыг 2021-2023 онд шийдвэрлэнэ.

## Төслийн явц

- Нийт 875.7 сая ам.доллар шаардлагатайгаас 1-р модулийн барилгын ажилд 335.6 сая ам.долларыг өөрийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ.
- 2021-2023 онд нийт 30 сая тн нүүрс баяжуулах хүчин чадал бүхий үйлдвэрийн 1-р модуль буюу 10 сая тн-н үйлдвэрийг ашиглалтад оруулна.

## Нийгэм, эдийн засгийн ач холбогдол

- 928 ажлын байр шинээр бий болно.
- Жилд дунджаар \$306.5 сая татвар, төлбөр төвлөрүүлнэ.
- Олон улсын зах зээлд шаардлага хангасан бүтээгдэхүүнийг нийлүүлж өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

## ХАР ТӨМӨРЛӨГИЙН ЦОГЦОЛБОР

/2020-2024 он/

36

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ 2020-2021



**У**ул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийн хүрээнд “Кью Эс Си” ХХК Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд жилд 350 мян.тн ган цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай, мини домен зуухны технологид суурилсан, аргалж, хорголж, коксын үйлдвэрүүд, бусад дэд бүтцийг багтаасан, ган үйлдвэрлэх иж бүрэн цогцолбор бүхий “Монгол ган цогцолбор I” төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Төсөл хэрэгжсэнээр түүхий эдийн нөөцийн хамааралгүй, анхдагч гангаар үйлдвэрлэгдсэн өндөр чанарын ган бүтээгдэхүүнийг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх боломжтой болно.

**Үйлдвэр ашиглалтад орсноор**

Гол нэр төрлийн ган бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээний **30-50** хувийг хангана.

**325.7 мян.тн** төмрийн хүдрийн хорголж экспортод гаргана.



## 2020-2021 онд хийсэн ажлууд

“Кью Эс Си” ХХК нь бага оврын домен зуухны технологи бүхий цогцолбор үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын MCC-CERI компани болон Монгол Улсын “Кью Эм Си” зөвлөх компаниудтай хамтран боловсруулан 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн.

“Монгол ган цогцолбор I” төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 24 га газрыг Дархан-Уул аймгийн Засаг даргын захирамжаар 2021 оны 10 дугаар сарын 17-ны өдөр олгоод байна.

Цаашид төслийг ЕРС гэрээгээр хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан сонгон шалгаруулах, дараагийн шатны нарийвчилсан зураг, төсөл боловсруулах ажлыг эхлүүлэхээр төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

## Хүчин чадал

Жилд **350 мян.тн ган**  
бүтээгдэхүүн

## Үйлдвэрлэл

**200 мян.тн арматур**  
**80 мян.тн гөлгөр ган туйван**  
**40 мян.тн булан төмөр ба С төмөр**  
**30 мян.тн төмөр утас**

## Төслийн явц

- 2022 онд төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.
- Түүхий эд, материалын туршилт хийгдсэн.

## Нийгэм, эдийн засгийн ач холбогдол

- 1915 ажлын байр шинээр бий болно.
- Төмрийн хүдрийг дотооддоо боловсруулна.
- Шинэ техник, технологи эзэмших мэргэжилтэй боловсон хүчин бий болж ажлын байр нэмэгдэнэ.
- Дагалдах жижиг, дунд үйлдвэр хөгжинэ.

# ТАВАНТОЛГОЙ-ГАСУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ЦОГЦОЛБОР ТӨСӨЛ

/2020-2022 он/



**Т**авантолгой төмөр зам” ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 242, 2019 оны 304 дүгээр тогтоолын дагуу төмөр замын барилгын ажлыг 2020 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлж, 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Баян-Овоо сумын нутаг дэвсгэрээр 240 км үргэлжилж, Цогтцэций, Гашуунсухайт суурьшлын бүс болон 2 өртөө, 6 зөрлөгийн барилга байгууламжуудаас бүрдэх бөгөөд нэгдүгээр зэрэглэлийн UIC-60 зам төмөр бүхий уулзваргүйгээр 16 гүүр, 172

байршилд хиймэл байгууламжтайгаар баригдаж байна.


2021 оны гуравдугаар улирлын байдлаар төслийн талбайд 2300 орчим хүн, 800 орчим техник, хүнд машин механизмтайгаар ажиллаж байна. Төслийн доод бүтцийн ажил 96.8%-тай, ачилтын тойргийн газар шорооны ажил 100% дуусч, хил холболтын газар шорооны ажил 94.9%, эрчим хүч 61.5%, дохиолол холбоо 36.4%-ийн гүйцэтгэлтэй байна. Түүнчлэн өртөө, зөрлөг, удирдлагын байрны барилга угсралт болон орон сууцны барилгын ажлууд үргэлжилж, төслийн хэмжээнд нийт 220 км гол замын үеийг угсраад байна.





## Нийгэм, эдийн засгийн ач холбогдол

- БНХАУ руу экспортлох нүүрс тээврийн өртөг 40 ам.доллараос 8 ам.доллар болж, тонн тутамд 4 дахин буурна.
- Төмөр замаар дамжуулах нүүрс, зэсийн экспортын хэмжээ нэмэгдэж, БНХАУ төдийгүй тус улсын далайн боомтуудаар дамжин гуравдагч орон руу тээвэрлэлт хийх боломжтой болно.
- Монгол Улсын уул уурхайн компаниуд дэлхийн зах зээлд хямд үнээр өрсөлдөх боломж бүрдэнэ.
- Малын бэлчээр сүйтгэх, тоосжилт, дуу шуугиан, хөрс болон агаарын бохирдол үлэмж хэмжээгээр багасна.
- Авто тээврийн осол, зөрчил буурч, хөдөлгөөний аюулгүй байдал дээшилнэ.
- 2000 орчим тогтмол ажлын байр шинээр бий болно.



- Улсад жилд 20–28 сая ам.долларын татвар төлөхөөс гадна 25 жилийн хугацаанд ойролцоогоор 1 тэрбум ам.долларын ногдол ашиг Засгийн газарт өгч, улс орны эдийн засагт бодит дэмжлэг болно.
- Тавантолгойн бүлэг орд орчмын уурхайнуудын олборлолтын хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.



# ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН 416 КМ ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ /2020-2022 он/



**З**үүнбаян төмөр зам” ХХК нь Засгийн газрын 2020 оны 117-р тогтоолоор 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр байгуулагдаж, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих, эзэмших, ашиглах болон төмөр замын суурь бүтцийг ашиглан тээврийн үйл ажиллагаанд оролцох зорилгоор үйл ажиллагаа явуулж байна. Компанийн 66 хувийг “Эрдэнэс - Тавантолгой” ХК, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК эзэмшдэг. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам нь Өмнөговь, Дорноговь аймгийн таван сумын нутаг дэвсгэрээр дайран нэг өртөө, зургаан зэрлэгтэй 416 километр урт, 27 ширхэг гүүр, 595 ширхэг хоолой бүхий Р65 зам төмөртэй,

уулзвартай, гуравдугаар зэрэглэлийн төмөр зам юм.

Төмөр замын бүтээн байгуулалтад үндэсний 104 аж ахуйн нэгж оролцож, төслийн хугацаанд 10 мянга орчим хүн, 4 мянга орчим техник хэрэгсэл ашигласан.

Бүтээн байгуулалтын ажил 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төмөр замын доод бүтэц буюу газар шороо, хиймэл байгууламжийн ажлын ерөнхий гүйцэтгэгчээр Зэвсэгт хүчний Жанжин штаб, дээд бүтцийн ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “Улаанбаатар төмөр зам” ХНН ажиллаж байна.







## Нийгэм, эдийн засгийн ач холбогдол

- Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулан, олборлож боловсруулсан бүтээгдэхүүнийг БНХАУ болон ОХУ төдийгүй тус улсуудын далайн боомтуудаар дамжин гуравдагч орон руу тээвэрлэлт хийх боломжтой болно.
- Бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчдэд шууд хүргэн дэлхийн зах зээлд хямд үнээр, “далайн боомт”-ын нөхцөлөөр борлуулах боломжтой.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг Гашуунсухайт-Ганц мод чиглэлийн шинэ гарцтай холбох, цаашлаад Ханги-Мандал чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор транзит ачааны хувьд эдийн засгийн үр өгөөж өндөр байна.
- 1000 орчим тогтмол ажлын байр шинээр бий болно.
- Авто тээврийн осол, зөрчил буурч, хөдөлгөөний аюулгүй байдал дээшилнэ.



- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дагуух уул уурхайн ордуудын олборлолтын хэмжээ 2-3 дахин нэмэгдэх боломжтой.
- Төслийн бүтээн байгуулалтын явц 95%-тай байгаа бөгөөд нийт бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт өнөөдрийн байдлаар 1 их наяд 53 тэрбум төгрөгт хүрсэн.



# НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ


**“Ногоон гарц” түр журмыг батлан хэрэгжүүлж байна**



“Ковид-19” цар тахлын улмаас манай улсын эрдэс бүтээгдэхүүний экспорт буурч, тасалдах нөхцөл үүссэнтэй холбогдуулан уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, боомтуудын нэвтрэх чадварыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, УУХҮЯ-наас Монгол, Хятадын хамтарсан хилийн боомтын “Ногоон гарц” журмыг баталсан.

Энэхүү түр журмын хүрээнд Өмнөговь аймгийг “Ногоон бүс” болгон хамгаалж, боомтуудад халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн зохион байгуулсны үр дүнд нүүрс тээвэр 50 гаруй хувиар өсч, 2200 орчим тонноор нэмэгдсэнээр цар тахлын өмнөх үеийн экспортын хэмжээнд хүрсэн.

**Түр журмыг хэрэгжүүлснээр нүүрс тээврийн экспорт цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрэв**  
(мян.тн / 2020 он, сар)




## Булган боомтын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэв

Ховд аймгийн Булган боомтын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээнд Гадаад харилцааны яаманд хүсэлт гаргасны дагуу Булган-Такашикэн боомтын хүчин чадал, ажиллах цагийг нэмэгдүүлсэн.

Үүний үр дүнд 2021 онд нүүрсний экспорт эрс өссөн. Тухайлбал, 2019 онд тус боомтоор нийт 1,285.4 мян.тн, 2020 онд 760.4 мян.тн нүүрс гаргасан бол 2021 оны эхний 9 сарын байдлаар 1,035.5 мян.тн нүүрс экспортолжээ.

**Булган боомтын нүүрсний экспорт**  
(мян.тн)




### Чингэлэгт тээврийн терминалыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгууллаа

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам чингэлэгт тээврийн терминал байгуулах тухай саналыг 2020 оны 11 дүгээр сард Боомтын зөвлөлд оруулж, мөн оны 12 дугаар сард Шивээхүрэн боомтод нэмэлт гарц барих ажлыг хийж хэрэгжүүлэв. Судалгааны түвшинд боловсруулсан /хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах/ уг саналыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 185 дугаар тогтоолоор баталж, нүүрсний экспортын 95 орчим хувийг бүрдүүлдэг хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтод чингэлэгт тээврийн терминал байгуулахаар шийдвэрлэсэн. Гашуунсухайт боомтын чингэлэгт тээврийн терминалыг Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас 236 км зайд буюу тус боомтын зурвас газар болох 30 га талбайд байгуулахаар болж, 7 дугаар сарын 06-ны өдөр төслийн ажил эхэлсэн. Төслийг “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой”

ХК, “Тавантолгой” ХК-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн бөгөөд уг бүтээн байгуулалтад 17 туслан гүйцэтгэгч компанийн нийт 430 орчим инженер, техникийн ажилтнууд оролцож, хоёр сар хүрэхгүй хугацаанд амжилттай хийж гүйцэтгэв.

Шивээхүрэн боомтод барих чингэлэгт тээврийн терминалыг 11.6 га талбайд байгуулахаар төлөвлөж, Монгол Улсын Сангийн сайд, Хилийн Боомтын Үндэсний Зөвлөлийн даргын 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 21/05 дугаар зөвлөмжийн дагуу бүтээн байгуулалтын ажлыг 8 ААН-ийн нийт 46 инженер, техникийн ажилтнууд хамтран гүйцэтгэж байна. Төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажил, газар шорооны ажил хийгдсэн бөгөөд нийт 60 орчим хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн тус терминалыг байгуулах ажлын хүрээнд гаалийн хяналтын нэмэлт гарцыг “Монголын Алт” ХХК барьж, Хил хамгаалах ерөнхий газарт хүлээлгэн өгөөд байна.



### Алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд 313.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгов


Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч нарын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн А/102, А-177 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Алт-2” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилго бүхий хөнгөлөлттэй санхүүжилтийн түр журам хэрэгжиж буй.

Үүнд 2021 оны 3 дугаар 16-ны өдрийн А/52, А-82 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Энэхүү журмаар 6 хүртэлх сар буюу богино хугацаатай зээлийн санхүүжилтийн эргэн төлөлтийг 2021 он дуустал сунгаж, урт хугацаат зээлийн санхүүжилтийн эргэн төлөлтийг 24 сар хүртэл байсныг 36 сар хүртэл болгон өөрчлөв.



### Үнэт металл худалдан авалт (кг / 2021 он, сар)



Энэ хүрээнд Монголбанкнаас 2021 оны 9 дүгээр сарын байдлаар 333.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг давхардсан тоогоор 20 аж ахуйн нэгжид олголоо.

### Асгатын ордын төслийг АНУ-ын “КАП” компанитай хамтран хэрэгжүүлнэ /2021-2024 он/

Засгийн газрын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөрийн 3.1.2.5-т: “Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ” гэж тусгасан. Уг зорилтыг хэрэгжүүлснээр “Асгат”-ын мөнгө, полиметаллын ордын эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай геологи хайгуулын ажил явуулах, дэд бүтэц, уулын баяжуулах, боловсруулах, цэвэршүүлэх үйлдвэрийн инженерчлэл, барилгын ажлыг төлөвлөх, ордын ашиглах ТЭЗҮ-ийг боловсруулах, ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээний талаарх санал боловсруулж шийдвэрлүүлэх, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх нөхцөл бүрдэнэ.



### ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

- Уурхайн хэвтээ амнуудыг нээх, нэвтрэх, далд малталтуудаас технологийн дээж бэлтгэх ажлыг 2019 оны 11 дүгээр сард эхлүүлэв.
- Ордын нөөцийн шинэчилсэн тооцооны тайланг 2020-2021 онд боловсруулж, ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой уурхайн түр хотхон тохижуулав.
- “Эрдэнэс Монгол” ХХК АНУ-ын “Commonwealth American Partners” ХХН хооронд “Хамтын ажиллагаа, түншлэлийн санамж бичиг”-ийг 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдөр байгуулав. “КАП” компани геологийн судалгааны эрсдэл, хамтарсан компани ба төслийг бүрэн хэрэгжүүлэхтэй холбогдох бүх санхүү техникийн эрсдлийг бүрэн хариуцахаар санамж бичигт тусгажээ.

### Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна /2021-2024 он/

Засгийн газрын үйл ажиллагааны 2020- 2024 оны хөтөлбөрийн 3.2.2.2-д: “Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна” гэж тусгасан. Төсөл хэрэгжих хугацаанд 4,010.1 мян.тн жоншны хүдэр олборлож, хүдэр ялгах үйлдвэрт нийт 2,849.8 мян.тн-ыг ялган авч, “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэрт нийлүүлэн ФФ-95 маркийн флотацын баяжмал үйлдвэрлэнэ. Баяжмал үйлдвэрлэлийн хүчин чадал жил тутам 45.5 мян.тн байх бөгөөд төслийн хугацаанд 911.9 мян.тн баяжмал үйлдвэрлэнэ.

### ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

- Ордыг далд аргаар ашиглах ТЭЗҮ-ийг боловсруулж, ЭБМЗ-ийн 2021 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулах гэрээг байгуулсан бөгөөд эрчим хүчний хангамжийн тендер зарлагдаад байна.
- Уурхайн налуу гол амны нэвтрэлтийн ажлыг эхлүүлээд байна.



## ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ БОНДЫГ АМЖИЛТТАЙ АРИЛЖЛАА

**М**онгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эдийн засгийг сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ЭТТ бондыг хэрэгжүүлж буй бөгөөд уг бонд нь дотоодын хөрөнгийн бирж дээр анх удаагаа гадаад валютаар буюу ам.доллараар гарч байгаа учраас ханшийн уналтаас хамгаалагдсанаараа давуу талтай юм.

“Монголын Хөрөнгийн Бирж”, “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ны тогтоол болон “Анхдагч зах зээл дээр арилжаалах” албан ёсны зөвшөөрлийг тус тус олгосноор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн орлогоор баталгаажсан, 100,000 төгрөг болон 100 ам.долларын нэрлэсэн үнэтэй, хоёр жилийн хугацаатай “ЭТТ бонд”-ын анхдагч зах зээлийн арилжааны захиалга 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан. Харин II үе шатны арилжааны захиалгыг 2021 оны 8 дугаар сарын 16-ны өдрөөс 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулав. Бондын санхүүжилт нь Тавантолгой дулааны цахилгаан станц, Нүүрс баяжуулах үйлдвэр, Усан

хангамж, Төмөр зам зэрэг үндэсний томоохон бүтээн байгуулалтад зарцуулагдана. Дээрх бүтээн байгуулалтууд хийгдсэнээр компанийн үр ашиг илүү нэмэгдэж, 2025 он хүртэл нийт 11.5 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөж байна.



# МОНГОЛ УЛСЫН УУЛ, УУРХАЙН САЛБАР “БАЯЛГИЙН ЗАСАГЛАЛЫН ИНДЕКС”-ИЙН ХАНГАЛТТАЙ ҮНЭЛГЭЭГ ХАДГАЛЛАА

**N**atural Resource Governance Institute буюу Байгалийн Баялгийн Засаглалын Хүрээлэнгээс гаргадаг “Баялгийн Засаглалын Индекс” /БЗИ/-ээр Монгол Улсын уул уурхайн салбар “хангалттай” үнэлгээг хадгалсан бөгөөд энэ нь өмнөх 2017 онд тооцсон дүнгээс 6 оноогоор өссөн үзүүлэлт юм.

Манай улсын 2021 оны БЗИ нь нийт 100-аас 70 оноо болж, 2017 оны үнэлгээнээс бага зэрэг өсөхөд “Орлогын менежмент” үзүүлэлтийн хувьд ахиц гарсан нь нөлөөлжээ. Мөн Монгол Улсын Засгийн газраас цахим шилжилт хийхэд гаргаж буй хүчин чармайлттай холбоотойгоор “Нээлттэй өгөгдөл” хэсэгт өндөр оноо авч,


улмаар “Дэмжигч орчин”-ы үнэлгээ сайжирсан нь голлон нөлөөлсөн байна.

БЗИ-ээр баялаг ихтэй 18 улсын газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын нөөц баялгаа хэрхэн удирдаж байгааг үнэлдэг. Индексийн ерөнхий үнэлгээ нь гурван бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнээс хоёр нь олборлох салбарын салшгүй онцлог болох “Үнэ цэн хүртэх байдал” болон “Орлогын менежмент”-ийг хэмждэг бол гурав дахь нь засаглалын ерөнхий нөхцөл байдал буюу үйл ажиллагаа “Дэмжигч орчин”-ыг үнэлдэг. Засаглалын энэхүү гурван ерөнхий хэмжүүр нь 14 дэд хэсэг буюу 51 үзүүлэлтээс бүрдэх бөгөөд тэдгээрийг нийт 136 асуултыг нэгтгэх замаар үнэлдэг байна.

## МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАР

2021 оны Баялгийн засаглалын индекс ба бүрэлдэхүүн хэсгийн оноо

### Баялгийн засаглалын индекс




Монгол Улсын БЗИ нь хангалттай түвшинд хүрэв.

70/100

#### ҮНЭЛГЭЭНИЙ АНГИЛАЛ


- САЙН  
75-с дээш оноо
- ХАНГАЛТТАЙ  
60-74 оноо
- СУЛ  
45-59 оноо
- ХАНГАЛТГҮЙ  
30-44 оноо
- МУУ  
30-аас доош оноо



61/100

### Үнэ цэн хүртэх байдал


Олборлолтын лиценз олголт, хайгуул, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, байгаль орчны хамгаалал, орлого бүрдүүлэх, төрийн өмчит компаниудтай холбоотой засаглалын чанарын хэмжүүр



71/100

### Орлогын менежмент

Улсын төсвийн төлөвлөлт, орон нутагт баялгийн орлого хуваарилалт, Үндэсний баялгийн сангийн чанарын хэмжүүр




78/100

### Дэмжигч орчин

Улс орны засаглалын ерөнхий чанарын хэмжүүр

## ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА



**О**лборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС) гэдэг нь байгалийн баялгаас (ашигт малтмал, газрын тос, байгалийн хий) олж буй орлогыг олон нийтэд ил тод болгосноор түүнийг нийтийн сайн сайхны төлөө зөв захиран зарцуулахад оролцогч талуудын хариуцлагыг өндөржүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий дэлхий нийтийн түншлэл юм.

Одоогоор байгалийн баялаг ихтэй дэлхийн 55 орон ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй бөгөөд Монгол Улс 2006 онд тус санаачилгад нэгдэн орсон.

Монгол Улс 2020 онд 15 дахь удаагийн нэгтгэл тайланг гаргаад байна.


Монголын ОУИТБС-ын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл бөгөөд УУХҮ-ийн сайд тэргүүлдэг. Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийг тэнцүү тоогоор төлөөлсөн нийт 30 гишүүний бүрэлдэхүүнтэй.

Төр, компани, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий олон талт оролцогчдын бүлгийн хамтын удирдлага дор явагддаг уг санаачилгын хүрээнд дараах мэдээллүүд ил болдог. Үүнд:


- Тусгай зөвшөөрөл
- Нөөцийн мэдээлэл
- Төрөл бүрийн гэрээ
- Бүтээгдэхүүн олборлолт, үйлдвэрлэл, борлуулалт
- Улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр хураамж
- Орлогын хуваарилалт, зарцуулалт
- Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, хандив, дэмжлэг зэрэг нийт 42 хавсралт бүхий өгөгдөл, мэдээлэл, нэгтгэл тайланг дагалдан ил тод болж байна.

### Олборлох салбарын ил тод орлого нэгдсэн төсөвт эзлэх хувь

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгтгэл тайлангаар хэдий хэмжээний орлого ил болдог вэ. Ил тод болсон энэхүү орлогын хэмжээг ҮСХ-ны үзүүлэлттэй жишиж үзвэл дараах харьцуулалт гарч байна.



ОУИТБС




Эх сурвалж: ҮСХ

2020 оны байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшигч 2240 аж ахуйн нэгжийн 63.3 хувь нь ил тодын тайлангаа тайлагнасан бол Засгийн газрын долоон агентлаг, 17 аймаг, нийслэлийн 6 дүүргийн ЗДТГ олборлогч компаниудаас хүлээн авсан орлогоо тайлагнажээ.

# УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ

## Дотоодын нийт бүтээгдэхүүн

Монгол Улсын Уул уурхай, олборлох салбар Дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувийг эзэлж байна. (2021 эхний хагас жил)




## Төсвийн нийт орлого

Эрдэс баялгийн салбар Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 30.4 хувийг бүрдүүлж байна. (2021 I-X сар)



## Гадаадын шууд хөрөнгө оруулалт


Уул уурхай, олборлох салбар Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80.3 хувийг бүрдүүлж байна. (2021 эхний хагас жил)






### Эрдэс баялгийн экспорт

Монгол Улсын нийт экспортын 93.2 хувийг Эрдэс баялгийн экспорт эзэлж байна. (2021 I-X сар)



### Аж үйлдвэрийн салбар (НБҮ)


Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 68.7 хувийг уул уурхай, олборлох салбар бүрдүүлж байна. (2021 I-X сар)



### Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл

Монгол Улсад хайгуулын 927, ашиглалтын 1740 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. (2021.10.29)





# ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОС, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТҮҮХЭН ТОВЧООН

1922-2021 он



## ТҮҮХЭН ТОВЧООН



**1923**

Уул уурхайн дүрмийг баталснаар ашигт малтмал эрж хайх, олборлох явцыг журамлав

**1922**

Ардын ЗГ-ын шийдвэрээр Налайхын уурхайг улсын мэдэлд авснаар орчин үеийн уул уурхайн салбар үүсч хөгжих эхлэл тавигдав



**1931**

БНМАУ-ын нутаг дэвсгэрт геологи хайгуулын ажил явуулах тухай анхны гэрээг Монгол-Зөвлөлтийн ЗГ хооронд байгуулав

**1942**

Чоно голын гянтболдын уурхайг байгуулсан нь Монголын анхны хүдрийн уурхай бөгөөд эксковатор, бульдозер, өрмийн машин зэрэг техникийг анх нэвтрүүлэв



**1947**

Н.И.Хомизури нар Мөрөн, Цэнхэр голын районд 1:50 000-ны масштабын анхны зураглалын ажил хийв

**2010**

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг байгуулав.



Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хууль батлагдав

**2009**

МУ-ын ЗГ болон “Айвенхоу Майнз Монголия Инк” ХХК, “Айвенхоу Майнз Лимитед”, “Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед” нарын хооронд Оюутолгойн ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулав

Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан, усан сангийн хамгаалалтын бүсэд ашигт малтмалыг хайх, ашиглахыг хориглох тухай хууль батлагдав


Цөмийн энергийн тухай хууль батлагдав

Тавантолгойн нүүрсний ордын Ухаа худгийн хэсгийн уурхайн үйл ажиллагааг эхлүүлэв

**2006**

Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн найруулснаар төрийн оролцоо бий болов

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль батлагдав



**2014**

Төрөөс эрдэс баялгийн салбарын талаар баримтлах бодлого батлагдав

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль батлагдав

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгох эрх зүйн орчин бүрдэв

**2017**

УИХ, Засгийн газар БНЭУ-аас олгож буй хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар шийдвэрлэв



**2019**

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэв

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 240 км төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлэв

**2013**

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдав

Оюутолгойн уулын баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэв



## 1922-2021 он



**1954**

Бэрхийн хайлуур жоншны уурхай нээгдэв

**1968**

Монгол орны хувьд анх удаа Өмнөговь аймгийн Ханбогд сум орчмын шүлтлэг боржингоос шинэ эрдэс тогтоож Армстронгит гэж нэрлэв


**1972**

Толгойтын алтны үйлдвэр байгуулагдсан нь монголын алтны ууган үйлдвэр юм

**1978**


Жилд 4.0 сая тонн хүдэр олборлон баяжуулах хүчин чадалтай Эрдэнэт үйлдвэрийн эхний ээлжийг ашиглалтад оруулав

Багануурын нүүрсний уурхай ашиглалтад оров



**1985**

Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулав



**1988**

Газрын хэвлийн тухай хууль батлагдсанаар Монгол Улсад ашигт малтмалын хайгуул, ашиглалт явуулах эрх зүйн шинэ орчин бүрдэв



**1990**

Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн амыг нээж ашиглалтад оруулав

**1991**

Алт, Алт-2 хөтөлбөрийг 1991-2000 онд хэрэгжүүлэв

**2005**

Бороогийн алт, Төмөртийн Овоогийн уулын баяжуулах үйлдвэр ашиглалтад оров

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай анхны хууль батлагдав



**1997**

Ашигт малтмалын тухай хууль шинэчлэн батлагдсан нь Монгол Улсад хөрөнгө оруулалт татах хууль эрхзүйн орчин бүрдэв

ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар байгуулагдав

**1996**

УИХ-ын 40 дүгээр тогтоол, ЗГ-ын 303, 305 дугаар тогтоолоор Газрын тосны хэрэг эрхлэх газрыг байгуулав

**1994**

Жилд 100.0 мянган тонн ган цувимал үйлдвэрлэх хүчин чадалтай Дарханы хар төмөрлөгийн цогцолборыг ашиглалтад оруулав

Ашигт малтмалын анхны хууль батлагдсанаар хууль эрх зүйн шинэ орчин бий болов



**2020**

Үндэсний геологийн албыг байгуулав

Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэв



Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулав

**2021**

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулав

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг боловсруулав

Ашигт малтмалын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулав

Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулав

"Эрдэнэс Тавантолгой" ХК ЭТТ бонд гаргав




# УУЛ УУРХАЙН САЛБАРААС 2022 ОНД ₮4.3 ИХ НАЯДЫН ОРЛОГО БҮРДҮҮЛНЭ

Энэ нь улсын нэгдсэн төсвийн  
орлогын **26 хувь** болно.

Монгол Улсын 2022 оны төсвийн  
тухай хуулийн төсөлд:

ЭКСПОРТ







УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот,  
Нэгдсэн Үндэстний гудамж - 5/2  
Засгийн Газрын II байр  
**Утас:** (51)-2635068, (51)-260864  
**Цахим шуудан:** [info@mmhi.gov.mn](mailto:info@mmhi.gov.mn)  
**Фэйсбүүк page:** Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам  
**Твиттер:** @ministry\_mining



[mmhi.gov.mn](http://mmhi.gov.mn)